



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

**“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин болон контрактын биелэлтийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Л.Батжаргалтай байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Л.Батжаргалтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002249